



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ТӨРӨӨС ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН ӨРНҮҮЛЭХ  
ЧИГЛЭЛЭЭР ТОДОРХОЙЛСОН ХӨТӨЛБӨРИЙН  
ХҮРЭЭНД ХОРШООНЫ ГИШҮҮН МАЛЧДАД  
ХӨНГӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОСОН БОЛОВЧ  
ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: “ ”ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-Д  
ОЛГОСОН ЗЭЭЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТ, ҮР ДҮН”**

**АУДИТЫН КОД: БӨА-2026/21-2/ШТА-ГА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,  
аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: [nazguld@audit.gov.mn](mailto:nazguld@audit.gov.mn)

Аудитор: Р.Баярмаа

Утас: 99265539 Цахим хаяг: [Bayarmaar@audit.gov.mn](mailto:Bayarmaar@audit.gov.mn)

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: [NurlanSH@audit.gov.mn](mailto:NurlanSH@audit.gov.mn)

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: [Erkebulankh@audit.gov.mn](mailto:Erkebulankh@audit.gov.mn)

Өлгий хот  
2026 он

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                       |            |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|
| Товчилсон үгийн тайлбар.....                                                                                                                                                                          | 2          |
| Хүснэгтийн товъёог .....                                                                                                                                                                              | 3          |
| Графикийн товъёог .....                                                                                                                                                                               | 3          |
| Хавсралтын товъёог: .....                                                                                                                                                                             | 3          |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....                                                                                                                            | 4          |
| Ерөнхий мэдээлэл .....                                                                                                                                                                                | 6          |
| БҮЛЭГ 1. Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна .....                                                                                         | 7          |
| А.1.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" тогтоолыг хэрэгжүүлэх аймгийн дэд төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ажилласан байна .....                                                                  | 7          |
| 1.1.2 Аймгийн "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгийн эх үүсвэрийг тусгаж төлөвлөсөн байна ..... | 7          |
| 1.1.3 "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.....                                        | 7          |
| БҮЛЭГ 2. Хоршоог байгуулахдаа хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа үнэн зөв тайлагнаж ажиллаагүй байна .....                                                     | 10         |
| 2.1. Шинээр үүсгэн байгуулагдсан хоршоод үүсгэн байгуулагдахдаа хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа үнэн зөв тайлагнаж ажиллаагүй байна ..                      | 10         |
| 2.1.1 Хоршоод “хоршоог үүсгэн байгуулах” гэрээ байгуулаагүй байна.....                                                                                                                                | 10         |
| 2.1.2 Хоршоод дүрэмдээ үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна. ....                                                       | 11         |
| 2.1.3 Хоршоод хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулаагүй байна.....                                                                                                                            | 12         |
| 2.1.4 Хоршооны тухай хуульд заасны дагуу хоршооны дүрэмдээ болзошгүй эрсдэлээс хамгаалах сан, заавал байлгах хөрөнгийн хэмжээг тусгасан боловч , хөрөнгө байршуулаагүй байна.....                     | 12         |
| 2.1.5 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 61.3 хувь нь холбогдох хууль, журам, зааварт заасны дагуу тайлан гаргаагүй, бүртгэл хөтлөөгүй байна .....                                               | 13         |
| 2.2 “Хоршооны гишүүн малчны зээл” олгохдоо санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан шалгуурыг баримтлаагүй байна .....                                                                                    | 13         |
| 2.2.1 Ерөнхий гэрээний 3.1.2, 3.1.3-д заасан шалгуур хангаагүй 64 зээлдэгчид зээл олгосон байна.....                                                                                                  | 13         |
| 2.2.2 Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж байна .....                                                                                                                                       | 16         |
| 2.2.3 Арилжааны банкнууд хоршооны гишүүн малчны зээлд журамд заасны дагуу тогтмол хяналт хэрэгжүүлээгүй, хяналт үр дүнгүй байна.....                                                                  | 18         |
| 2.2.4 Хөнгөлөлттэй зээл авсан малчдын 1 хувь нь зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна20                                                                                                          |            |
| ДҮГНЭЛТ: .....                                                                                                                                                                                        | 22         |
| ЗӨВЛӨМЖ:.....                                                                                                                                                                                         | 233        |
| ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ :.....                                                                                                                                                                | 244-<br>26 |
| ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....                                                                                                                                                                    | 27-28      |

**Товчилсон үгийн тайлбар**

|         |                                              |
|---------|----------------------------------------------|
| УИХ     | Улсын Их Хурал                               |
| ЗГ      | Засгийн газар                                |
| ҮАГ     | Үндэсний аудитын газар                       |
| МУЕА    | Монгол улсын Ерөнхий аудитор                 |
| ШТА     | Шууд тайлагнах ажил                          |
| ГА      | Гүйцэтгэлийн аудит                           |
| АДБОУС  | Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт |
| ИТХ     | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                 |
| ЗДТГ    | Засаг даргын тамгын газар                    |
| ХХААГ   | Хүнс, хөдөө аж ахуйн газар                   |
| ХХҮГ    | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар       |
| ХЭДС    | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан               |
| ЖДҮ     | Жижиг, дунд үйлдвэрлэл                       |
| ЗБХМ    | Зээлийн багц хариуцсан менежер               |
| ТТХМ    | Тооцооны төв хариуцсан мэргэжилтэн           |
| ХААН    | Хөдөө ах ахуйн банк                          |
| ХХААХҮЯ | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам   |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |
|         |                                              |

### Хүснэгтийн товъёог

|           |                                                                         |       |
|-----------|-------------------------------------------------------------------------|-------|
| Хүснэгт 1 | Арга хэмжээний биелэлт                                                  | 10    |
| Хүснэгт 2 | Хоршоог үүсгэн байгуулагчдын оруулсах хувь хөрөнгийн судалгаа           | 11    |
| Хүснэгт 3 | “Хоршооны гишүүн малчны зээлийн” шалгуур хангаагүй зээлдэгчийн судалгаа | 14    |
| Хүснэгт 4 | Банкуудын зээлийн шалгуур хангаагүй зээлдэгчийн тооны мэдээлэл          | 15    |
| Хүснэгт 5 | Шалгуур хангаагүй зээлийн дүн                                           | 15    |
| Хүснэгт 6 | Баян-Өлгий аймгийн “Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээлэл             | 16    |
| Хүснэгт 7 | Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон малчны зээлийн үлдэгдэл         | 17    |
| Хүснэгт 8 | Зээлийн чанарын байдал                                                  | 17    |
| Хүснэгт 9 | Хоршооны гишүүн малчны зээл”-д хэрэгжүүлсэн хяналт                      | 18-19 |
|           |                                                                         |       |
|           |                                                                         |       |
|           |                                                                         |       |
|           |                                                                         |       |
|           |                                                                         |       |
|           |                                                                         |       |

### Графикийн товъёог

|  |  |  |
|--|--|--|
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |
|  |  |  |

### Хавсралтын товъёог:

|  |  |  |
|--|--|--|
|  |  |  |
|  |  |  |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
|-------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>     | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар “Аудитын сэдэв батлах тухай” тогтоолоор баталсан Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэх аудитын сэдэв, МУЕА-ын 2026 оны А/179 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг гүйцэтгэнэ.                                                                                                                                                                                   |
| <b>Аудитын зорилт</b>                     | <p>Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хүрээнд малчинд олгосон зээл, эргэн төлөлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүнг УИХ-ын холбогдох Байнгын хороо, шалгагдагч байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"><li>• Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;</li><li>• Хоршоог хуульд заасан шаардлагын дагуу байгуулж, олгосон зээлийг зориулалтын дагуу ашиглаж, үр дүнг тооцож байгаа эсэх;</li></ul> |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>             | Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор баталсан "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагууд аймгийн ЗДТГ, ХХААГ, Улсын бүртгэлийн хэлтэс, Статистикийн хэлтэс, аймаг дахь Монгол банк, Төрийн банк, Хаан банкны салбар, шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд 2024-2025 онд зээл авсан 151 хоршооны 310 малчдыг хамруулав.                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>Аудитын хязгаарлалт</b>                | Үгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b> | Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 3000, 4000, Монгол Улсын төрийн аудитын багц стандарт MNS 6817-2020 “Төрийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан холбогдох байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, эрх бүхий                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |

|                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|---------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудитын<br/>бүрэлдэхүүн,<br/>хугацаа</b> | <p>байгууллагын хяналтын тайлан, цахим болон цаасан суурьтай нотлох баримтад үндэслэн асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг горим, арга зүйг ашиглав.</p> <p>Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, аудитын менежер Х.Женисбек хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл ахалж, аудитор Р.Баярмаа, Ш.Нурлан, Х.Еркебулан нар ҮАГ-ын нэгдсэн удирдамж аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хамтран гүйцэтгэв.</p> <p>Аудитын талбарын ажлыг 2026 оны 04 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж, аудитын тайланг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор илрүүлэлтийн бүртгэл, судалгааны хамт ҮАГ-т хүргүүлнэ.</p> |
| <b>Хүндрэл бэрхшээл</b>                     | <p>Аудит хийх явцад тус малын гоц халдварт шүлхий өвчин гарч хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой Алтай, Дэлүүн, Булган сумууд болон Буянт сумын зарим багт ажиллаагүй болно.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |

### **Ерөнхий мэдээлэл**

Монгол Улсын УИХ-аас Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр соёрхон баталж, 04 дүгээр сарын 24-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна.

Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэхээр 5 (тав) их наядын “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг баталж, 2 чиглэлийн хүрээнд 13 арга хэмжээг тусгасан байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг зарим арилжааны банкуудтай хамтран зохион байгуулж 2024, 2025 онд нийт 894.8 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Баян-Өлгий аймгийн 156 хоршооны 337 малчин 8.5 тэрбум төгрөгийн зээл авахаар хүсэлт гаргаснаас 150 хоршооны гишүүн 310 малчинд арилжааны 2 банкаар дамжуулж 7.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

**БҮЛЭГ 1. Төрөөс Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх чиглэлээр тодорхойлсон хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна**

**А.1.1. "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" тогтоолыг хэрэгжүүлэх аймгийн дэд төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ажилласан байна**

**1.1.2 Аймгийн "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгийн эх үүсвэрийг тусгаж төлөвлөсөн байна**

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр болгож “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг баталсан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан мал аж ахуйн салбарт үүсэж болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, малчдын хоршоог дэмжих замаар тогтвортой хөгжүүлэх зорилгоор “ Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх шийдвэр гаргасан.

Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын 3 дах заалтаар “Шинэ хоршоо хөдөлгөөний” ач холбогдол, үр нөлөөг харьяа нутаг дэвсгэртээ сурталчлан таниулах, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолтой уялдуулан зохион байгуулж, идэвхжүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар аймаг, сумын Засаг дарга нарт даалгаж, аймаг сумын ИТХ-ын дарга, багийн дарга нарт зөвлөснийг үндэслэж 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Баян-Өлгий аймгийн “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний дэд төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын дарга баталсан байна.

Тогтоолын хавсралтаар баталсан “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд үйл ажиллагааны 2 чиглэлээр, 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, үүнээс 6 арга хэмжээг аймаг, сумын ЗДТГ-уудтай хамтран хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Дээрх тогтоолын хэрэгжилтийн хангах зорилгоор Баян-Өлгий аймгийн Засаг дарга “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх аймгийн дэд төлөвлөгөөг баталж, үйл ажиллагааны 2 чиглэлээр 11 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгажээ.

Баян-Өлгий аймгийн “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрэх түвшин болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.6<sup>2</sup>, 5.1.10<sup>3</sup> дахь заалтуудыг баримталсан байна.

**1.1.3 "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна**

Төрөөс хэрэгжүүлж буй Шинэ хоршоо-чинээлэг малчин арга хэмжээний төлөвлөгөөг орон нутагт хэрэгжүүлэх байгууллага нь аймаг, сумдын ЗДТГ болон аймгийн ХХААГ байна.

5.1... Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална

5.1.6.нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;

5.1.10.шалгуур үзүүлэлт нь зорилготой нийцэж байх;



“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах үүднээс “Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах ажлын хэсэг болон хэрэгжилтийн явц, байдал, дүн мэдээг сум бүрээр хариуцах ажлын хэсгийг байгуулсан байна.

Мөн сумдын Засаг дарга нарт “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж оролцогчдын уялдаа, зохион байгуулалтаар хангаж ажиллах талаар үүрэг, чиглэл өгсөн байна.

Баян-Өлгий аймгийн “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хороонд тайлагнасан байна.

Баян-Өлгий аймгийн Засаг дарга “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх аймгийн дэд төлөвлөгөөнд тусгасан хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2 арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

1.1-д “Хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох” -оор төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангах, хамтран ажиллах талаар аймгийн Засаг даргын 2024 оны 1-01/847 дугаар албан бичгээр аймаг дахь Монгол банкны салбарт хандаж, мэдээлэл солилцож хамтран ажилласан байна.

1.2-т “Малжуулах хөтөлбөрт хамруулах”-аар төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлж аймгийн ХХҮГ-аас аймгийн хэмжээнд 110 малчин өрхөд батламж олгогдож, ХЭДС-аас 88.0 сая төгрөгийн хөрөнгө батлагдаж мал худалдан авч өгөх ажил хийгдсэн байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг идэвхжүүлэх, сурталчлах чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 9 арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

2.1-д тусгагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг эхлүүлэх, төв, орон нутгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотод 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөнийг эхлүүлэх төв орон нутгийн нэгдсэн арга хэмжээ”-нд тус аймгийн малчид, хоршоологчдын төлөөлөл болох 135 хүн оролцсон. Шинэ хоршоо-чинээлэг малчин” хөтөлбөрийг малчин өрхүүдэд таниулан сурталчлах, мэдээлэл өгөх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах зорилгоор сумуудаас 600 гаруй төлөөллийг оролцуулж аймгийн төвд “Шинэ хоршоо” малчдын зөвлөгөөн зохион байгуулсан.

2.2-т тусгагдсан “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий бүсийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд Ховд аймагт зохион байгуулагдсан “Шинэ хоршоо” хөдөлгөөний баруун бүсийн нээлтэд тус аймгийн малчид, тариаланчид, хоршоологчдын төлөөлөл 40 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

2.3-т тусгагдсан малчдад зөвлөн туслах, үүрэг бүхий сургагч багш нарыг бэлтгэх, сургалт зохион байгуулах арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан сургагч багш бэлтгэх сургалтад аймаг, сумдын ЖДҮ, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн зэрэг 15 хүн оролцсон байна. Аймагт “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг малчдад таниулан сурталчлах багийн ахлагч, гишүүдийг бэлтгэх сургалт зохион байгуулж 42 хүнийг хамруулсан.

2.4-т бэлтгэгдсэн багш нарыг орон хутагт ажиллуулж малчдыг идэвхжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/369 дүгээр захирамжаар “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөдөлгөөнийг орон

“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

*нутагт хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах ажлын 2 хэсгийг байгуулж сум бүрд 2 албан хаагч томилон ажиллуулсан.*

*2.5-т тусгагдсан “Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх мэдээллийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангаж аймгийн ЗДТГ-ын 2 дугаар байр болох Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд “Малчдад туслах үйлчилгээний цэг”-ийг байгуулсан.*

*2.6-т тусгагдсан “Мал аж ахуйн чиглэлийн хоршооны загвар төслүүдийг бэлтгэх” арга хэмжээг хэрэгжүүлж 15 төслийн загвар бэлтгэж малчид хоршоологчдод хүргүүлсэн.*

*2.7-д Малчдад зориулсан цахим системд шаардагдах мэдээллийг байршуулах” арга хэмжээний хүрээнд шаардлагатай мэдээллүүдийг байршуулснаар 24988 малчин мэдээлэл авсан байна. Хоршоо байгуулахад зөвлөн тусалсан тоо 2376, танилцуулга хийсэн өрхийн тоо 6716, иргэний тоо 25020, шинээр байгуулагдсан хоршооны тоо 258, шинэчилж байгуулсан хоршооны тоо 22, зээлийн хүсэлт гаргасан хоршооны тоо 150 байна.*

*2.8-д тусгагдсан “2024 оны хагас жилийн мал тооллогыг зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд түүврийн аргаар зохион байгуулж 3296 мал бүхий болон малчин өрхийг хамруулсан.*

*2.9-д тусгагдсан “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд газар олгох асуудлыг зохион байгуулах” арга хэмжээний хүрээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар 1 хоршоо хүсэлт гаргасан ба шийдвэрлэгдээгүй байна.*

Засгийн газраас хэрэгжүүлж буй урт хугацааны цогц бодлогын гол зорилго нь хоршоогоор дамжуулан малчин өрхийн амьжиргааг дэмжих, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг өсгөх, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилготой байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Шинэ хоршоо хөдөлгөөнийг эрчимжүүлэх хүрээнд 2024-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн 8 чиглэлийг тогтоож, тогтоолын хоёрдугаар хавсралтаар 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 тоот тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээнүүдээс аймгийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дэд төлөвлөгөө боловсруулан ажиллаж, хэрэгжилтийг тайлагнасан байна.

Аймгийн Засаг дарга Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны баталсан 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэж 2025 оны 02 дугаар сард аймгийн дэд төлөвлөгөөг баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2025 онд үйл ажиллагааны үндсэн дөрвөн чиглэлээр 7 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

-Үйл ажиллагааны үндсэн чиглэл 2 буюу “Малчдын хоршиж, хамтран ажиллах санаачлагыг дэмжих” чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх 4 арга хэмжээ,

-Үйл ажиллагааны үндсэн чиглэл 3 буюу “Хоршоодыг чадавхжуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн, жишиг хоршоо хөгжүүлэх, гадны орны туршлага судлах, сургалт зохион байгуулах” чиглэлийг хүрээнд хэрэгжүүлэх 1 арга хэмжээ,

-Үйл ажиллагааны үндсэн чиглэл 4 буюу “Хоршоодыг дотоодыг болон гадаадын зах зээлтэй холбох, жишиг стандарт нэвтрүүлэх, бүсчилсэн хөгжлийн

“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

бодлогтой уялдуулан ханган нийлүүлэлтийн сүлжээг кластераар хөгжүүлэх” чиглэлээр хэрэгжүүлэх 1 арга хэмжээ,

-Үйл ажиллагааны үндсэн чиглэл 6 буюу “ Зээл авсан хоршоодын санхүүгийн хяналт, ил тод байдлыг сайжруулах, зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээ авах” чиглэлээр хэрэгжүүлэх 1 арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

Хүснэгт 1. Арга хэмжээний биелэлт

| №                                | Төлөвлөсөн арга хэмжээ                                                                                                                                                                                                          | Биелэлт хувиар |
|----------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл 2. |                                                                                                                                                                                                                                 |                |
| 2.1                              | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан бүс нутаг тус бүрт шинээр байгуулагдах хоршоодод дэмжлэг үзүүлэх                                                                                                    | 100            |
| 2.2                              | Шинэ хоршоо хөдөлгөөний хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэртээ хангах, орон нутгийн төсөв, холбогдох нэгж, салбарын бүтэц орон тоондоо зохион байгуулалт хийж хариуцсан бүтэц бий болгож малчдад зөвлөн туслах цаг гаргаж ажиллах | 100            |
| 2.3                              | Малчдын хоршоонд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх чиглэлээр газар эзэмшүүлэх                                                                                                                                                      | 70             |
| 2.4                              | Малчдын усан хангамжийг нэмэгдүүлэх, ардын хөв, цөөрөм байгуулах, булаг шандын эх ундаргыг хамгаалах                                                                                                                            | 50             |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл 2. |                                                                                                                                                                                                                                 |                |
| 3.1                              | Хоршоолол хөгжсөн гадаадын орнуудад туршлага судлах, дотоодын бүтээгдэхүүнийг сурталчлах үзэсгэлэн худалдаанд оролцуулах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах                                           | 100            |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл 2. |                                                                                                                                                                                                                                 |                |
| 4.1                              | Малын хашаа хороо барих, булаг шандын эх. бэлчээр хамгаалах, хашаалах зэрэгт хуванцар хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн байгальд ээлтэй материал ашиглах боломжийг судалж нэвтрүүлэх                                        | 100            |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл 2. |                                                                                                                                                                                                                                 |                |
| 6.1                              | Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдалд үндэслэн зорилтот хоршоодод холбогдох дэмжлэг үзүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллах                                                                     | 100            |
| Биелэлтийн дүн                   |                                                                                                                                                                                                                                 | 88.5           |

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн “Шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах” үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

**БҮЛЭГ 2. Хоршоог байгуулахдаа хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа үнэн зөв тайлагнаж ажиллаагүй байна**

**2.1. Шинээр үүсгэн байгуулагдсан хоршоод үүсгэн байгуулагдахдаа хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа үнэн зөв тайлагнаж ажиллаагүй байна**

**2.1.1 Хоршоод “хоршоог үүсгэн байгуулах” гэрээ байгуулаагүй байна**

Хоршооны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хоршоог үүсгэн байгуулагчид хоршоо үүсгэн байгуулах талаар гэрээ байгуулж, уг гэрээнд хоршооны зорилго, үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана”, 8.2-т “Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсгэн байгуулах гэрээ дуусгавар болно” гэж заасан.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс аудитад хамрагдаж буй 150 хоршооны талаар ирүүлсэн баримт, материалд “Хоршоог үүсгэн байгуулах гэрээ” ирүүлээгүй.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудаст байршуулсан “Хоршоог шинээр бүртгүүлэх”-д шаардагдах бичиг баримтын жагсаалтад “Хоршоог үүсгэн байгуулах гэрээ” ороогүй байна.

Улсын бүртгэлийн байгууллага хоршоог шинээр бүртгэхдээ үүсгэн байгуулагчдын өргөдлийн маягт, нэрийн баталгаажуулалтын хуудас, бүх гишүүдийн хурлын тогтоол, дүрэм, гишүүдийн нийлүүлсэн хувь хөрөнгийн жагсаалтыг үндэслэн бүртгэсэн байна.

Хоршооны гишүүд хоршоог үүсгэн байгуулахдаа бүх гишүүдийн хурал хийж тэмдэглэлээр баталгаажуулж, гарсан шийдвэрийн дагуу тогтоолоор хоршооны нэр, дүрэм, хаяг, дарга, тэргүүлэгчид, гишүүдийн хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, үйл ажиллагаа эрхлэх чиглэл зэргийг баталсан байна.

Хоршооны бүх гишүүдийн хурлаар баталсан “Хоршооны дүрэм”-д хоршооны зорилго, эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан байна.

Аудитын явцад газар дээр явж шалгах үед уулзалт хийхдээ хоршооны гишүүдээс “Хоршоог үүсгэн байгуулах гэрээ” байгуулсан эсэх талаар тодруулахад энэ талаар байхгүй эсвэл мэдэхгүй гэсэн хариулт өгсөн бол хоршооны дарга нь гэрээ байгуулаагүй гэсэн тайлбар өгсөн.

Энэ нь Хоршооны тухай хуулийн 8.1, 8.2 дахь заалтууд хэрэгжээгүй буюу Улсын бүртгэлийн байгууллагын “Хоршоог шинээр бүртгэх” бичиг баримтын жагсаалтад ороогүй нь хуулийн 8.2 дахь заалттай нийцээгүй байна.

**2.1.2 Хоршоод дүрэмдээ үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.**

Аудитад хамрагдсан 150 хоршооны хувийн хэргийг хянаж үзэхэд 148 хоршоо дүрэмдээ үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээг тусган баталж Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.

Алтай сумын “Ботгын хүзүү”, Сагсай сумын “Сагсайн сайн малчид” хоршоонууд нь үүсгэн байгуулагчдын оруулах хөрөнгийн хэмжээг дүрэмдээ тусгаагүй, улсын бүртгэлийн гэрчилгээнд “0” төгрөгөөр бүртгүүлсэн байна.

Хүснэгт 2. Хоршоог үүсгэн байгуулагчдын оруулсан хувь хөрөнгийн судалгаа

| № | Нэг гишүүний оруулах<br>хөрөнгийн хэмжээ<br>/мян.төг/ | Хоршооны   |            |
|---|-------------------------------------------------------|------------|------------|
|   |                                                       | Тоо        | Хувь       |
| 1 | 10.0-500.0                                            | 119        | 80.4       |
| 2 | 501.0-1,000.0                                         | 19         | 12.8       |
| 3 | 1,000.1-2,777.8                                       | 10         | 6.8        |
|   | <b>Дүн</b>                                            | <b>148</b> | <b>100</b> |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Нийт хоршооны 119 нь буюу 80.4 хувь нь үүсгэн байгуулагчдын оруулах хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 10.0-500.0 мянган төгрөгөөр, 19 буюу 12.8 хувь нь 501.0-1,000.0 мянган төгрөгөөр, 10 буюу 6.8 хувь нь 1,000.1-2,777,8 мянган төгрөгөөр дүрэмдээ тусгаж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна.

### **2.1.3 Хоршоод хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийг байршуулаагүй байна**

Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Хоршооны дүрэмд дараах асуудлыг тусгана”, 10.3.21-т “хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хувь хэмжээ”, 27 дугаар зүйлийн 27.1.<sup>4</sup>, 27.2.<sup>5</sup>, 27.3.<sup>6</sup> дахь заалтуудад хоршооны хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлэх талаар заасан.

Аудитад хамрагдсан 150 хоршооны санхүүгийн тайлангаас харахад 144 хоршоо хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

Дэлүүн сумын 6 хоршоо 29.0-50.0 сая төгрөгөөр нийт 227.9 сая төгрөгийн хөрөнгийг хоршоо хөгжлийн санд байршуулснаар тайлагнасан боловч хөрөнгийг бодитоор байршуулаагүй, санхүүгийн тайланг үнэн зөв гаргаагүй байна.

Аудитын явцад хоршооны гишүүн зээлдэгч нартай хийсэн уулзалтаар хоршооны үйл ажиллагаа, тайлагналын талаар асууж тодруулахад, хоршооны гишүүд хоршооны дүрэм, үйл ажиллагааны талаар мэдээлэлгүй буюу хоршооны талаар ойлголтгүй байна.

### **2.1.4 Хоршооны тухай хуульд заасны дагуу хоршооны дүрэмдээ болзошгүй эрсдэлээс хамгаалах сан, заавал байлгах хөрөнгийн хэмжээг тусгасан боловч хөрөнгө байршуулаагүй байна**

Хоршооны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “”болзошгүй эрсдэлээс хамгаалах сан” гэж хоршоонд учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор энэ хууль болон хоршооны дүрэмд заасны дагуу хоршооны борлуулалтын орлогоос хуримтлуулах мөнгөн хөрөнгийг” гэж заасан.

Хоршооны дүрэмдээ болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгө, заавал байлгах хөрөнгийн хэмжээг тусгах талаар Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.20<sup>7</sup> дахь заалтад, хоршооны өөрийн хөрөнгийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилсан хөрөнгө болох талаар хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3<sup>8</sup>-т заасан ба энэ санд хөрөнгө хуваарилах талаар 25 дугаар зүйлийн 25.1.<sup>9</sup>, 25.2.<sup>10</sup>, 25.3.<sup>11</sup>, 25.4.<sup>12</sup> дэх заалтад хуульчилсан байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д хамрагдаж зээл авсан 150 хоршоо нь хоршооны дүрэмдээ болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хөрөнгө байршуулах талаар тусгасан боловч болзошгүй эрсдэлийн санд хөрөнгө хуваарилаагүй буюу хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоод Хоршооны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

27.1.Хоршооны хөгжил, хоршооны гишүүний нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэх, амьдралын чанар, амьдрах орчныг сайжруулах зорилгоор хоршоо хөгжлийн сантай байж болно.

27.2.Энэ хуулийн 26.1-д заасны дагуу хоршооны гишүүнд ногдох орлогыг хуваарилсны дараах орлогоос Хоршооны хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлнэ.

27.3.Хоршооны хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг захиран зарцуулах журмыг бүх гишүүдийн хурлаар батална.

10.3.20-д “болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулах хөрөнгийн хувь хэмжээ, уг санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ”

22.1.3.болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилсан хөрөнгө;

25.1.Хоршооны тухайн жилийн борлуулалтын нийт орлогын 20 хүртэл хувийг болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуваарилна

25.2.Болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хоршооны санхүүгийн тогтвортой байдлыг хангах, алдагдлыг нөхөх, эрсдэлийг бууруулахад ашиглана.

25.3.Болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглаж үл болно..

25.4.Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ нь хоршооны сүүлийн гурван жилийн борлуулалтын орлогын дунджийн 20 хувиас хэтрэхгүй байна.

### **2.1.5 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан хоршоодын 61.3 хувь нь холбогдох хууль, журам, зааварт заасны дагуу тайлан гаргаагүй, бүртгэл хөтлөөгүй байна**

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ний хүрээнд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 150 хоршооноос 92 хоршоо буюу 61.3 хувь нь санхүүгийн тайлан гаргаагүй, бүртгэл хөтлөөгүй ба Хоршооны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.<sup>13</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.<sup>14</sup>, 9 дүгээр зүйлийн 9.1.<sup>15</sup>, 14 дүгээр зүйлийн 14.1.<sup>16</sup> дэх заалтуудыг болон Сангийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 01-ны өдрийн А/155 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг зөрчсөн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.2-т “Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр хүлээн авсан харилцагч санхүүгийн байгууллага нь дараах үүрэг хүлээнэ”, 9.2.1-д “санхүүгийн тайланг энэ хуулиар тогтоосон хугацаанд тайлагнаж байгаа эсэхийг хянах” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын дүнгээр “Шинэ хоршоо хөдөлгөөн”-д хамрагдаж зээл авсан 150 хоршооноос 92 хоршоо нь нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, санхүүгийн тайлан гаргаагүй байгаа тул аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст “Хоршооны гишүүн малчны зээл” авсан хоршоодын санхүүгийн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж ажиллахыг **зөвлөмж** болгов.

## **2.2 “Хоршооны гишүүн малчны зээл” олгохдоо санхүүжилтийн ерөнхий гэрээнд заасан шалгуурыг баримтлаагүй байна**

### **2.2.1 Ерөнхий гэрээний 3.1.2, 3.1.3-д заасан шалгуур хангаагүй 64 зээлдэгчид зээл олгосон байна**

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Баян-Өлгий аймагт нийт 150 хоршооны гишүүн 310 малчинд зээл олгосон байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд гэрээний 3 дугаар зүйлд заасан “Зээл хүсэгчид тавих шаардлага”-ын талаар 3.1<sup>17</sup> 3.1.1<sup>18</sup>, 3.1.2<sup>19</sup>, 3.1.3<sup>20</sup>, 3.1.4<sup>21</sup>, 3.1.5<sup>22</sup>, 3.1.6<sup>23</sup> дахь заалтууд 3.1.7<sup>24</sup>-д заасан банкнаас зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам, зааврын хүрээнд тавигдах бусад холбогдох шаардлагуудыг баримталж зээл олгох талаар тусгасан байна.

23.1-д “Хоршооны хөрөнгө, эх үүсвэрийг энэ хуульд заасан журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ”

4.2-т “Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засагийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ”,

9.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангаа энэ хуулиар тогтоосон хугацаанд харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх үүрэгтэй”

14.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”

3.1. Зээлдэгч нь дараах бүх шаардлагыг хангасан байна:

3.1.1. Зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх

3.1.2 Үндсэн зээлдэгчийн нэр дээр мал тооллогод хамрагдсан байх

3.1.3 Хоршооны үйл ажиллагаагаа эрхлэх хот, аймагт оршин суудаг байх

3.1.4 Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өр төлбөрийн үлдэгдэлгүй байх

3.1.5 Гишүүнчлэлтэй хоршоо нь бизнес төлөвлөгөөтэй байх бөгөөд зээлдэгч нь бизнес төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх гэрээг хэрэгжүүлэгч талуудтай байгуулсан байх

<sup>23</sup>3.1.6 Суурийн барилга, байгууламж барих, өргөтгөх зориулалтаар хүсэлт гаргасан зээл хүсэгч нь өөрийн эсхүүл хоршоо, хоршооны бусад гишүүдийн нэр дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй газартай байх

3.1.7 Банкнаас зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам, зааврын хүрээнд тавигдах бусад холбогдох

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Гэрээний 3.1.1 болон 3.1.2-т заасан шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ийн “Малчны тодорхойлолт” болон “Мал тооллогын бүртгэл”-ийн лавлагаагаар тодорхойлно гэж заасан байна.

Хүснэгт 3. “Хоршооны гишүүн малчны зээлийн” шалгуур хангаагүй зээлдэгчийн судалгаа

| № | “Хоршооны гишүүн малчны зээл” хүсэгчид тавих шалгуур                                                                                                                                         | Нийт зээлдэгчийн тоо | Шалгуур хангасан зээлдэгчийн |        | Шалгуур хангаагүй зээлдэгчийн |       |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|------------------------------|--------|-------------------------------|-------|
|   |                                                                                                                                                                                              |                      | Тоо                          | Хувь   | Тоо                           | Хувь  |
| 1 | Зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх                                                                                                                                                   | 310                  | 310                          | 100%   | -                             | -     |
| 2 | Үндсэн зээлдэгчийн нэр дээр мал тооллогод хамрагдсан байх                                                                                                                                    | 310                  | 249                          | 80.3%  | 64                            | 19.7% |
| 3 | Хоршооны үйл ажиллагаа эрхлэх хот, аймагт оршин суудаг байх                                                                                                                                  | 310                  | 307                          | 99.0%  | 3                             | 1.0%  |
| 4 | Хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өр төлбөрийн үлдэгдэлгүй байх                                                                                                                             | 310                  | 310                          | 100.0% | -                             | -     |
| 5 | Гишүүнчлэлтэй хоршоо нь бизнес төлөвлөгөөтэй байх бөгөөд зээлдэгч нь бизнес төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх гэрээг хэрэгжүүлэгч талуудтай байгуулсан байх                                    | -                    | -                            |        | -                             | -     |
| 6 | Суурийн барилга, байгууламж барих, өргөтгөх зориулалтаар хүсэлт гаргасан зээл хүсэгч нь өөрийн эсхүл хоршоо, хоршооны бусад гишүүдийн нэр дээр өмчлөх, эзэмших, ашиглах эрхтэй газартай байх | -                    | -                            |        | -                             | -     |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлээс санхүүжилтийн ерөнхий гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.2-д заасан “Үндсэн зээлдэгчийн нэр дээр мал тооллогод хамрагдсан байх” шалгуурыг хангаагүй, 3.1.3-д заасан “Хоршооны үйл ажиллагаа эрхлэх хот, аймагт оршин суудаг байх” шалгуурыг хангаагүй давхардсан тоогоор 64 зээлдэгчид зээл олгосон байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3 дугаар зүйлийн 3.1-д заасан “Зээлдэгч дараах бүх шаардлагыг хангана” гэснийг зөрчиж 64 малчин иргэнд хоршооны гишүүн малчны зээл олгосон ба энэ нь зээлдэгчийн 20.6 хувийг эзэлж байна.

Ерөнхий гэрээнд заасан зээл олгох шалгуурыг бүрэн хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг бүрэн бүрдүүлж, баталгаажуулалгүй 64 зээлдэгчид зээл олгосон нь арилжааны банк зээл олгох үйл ажиллагаанд тавих урьдчилсан хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Аймгийн Статистикийн хэлтсээс авсан 2023-2025 оны мал тооллогын судалгаанаас харахад дээрх шалгуур хангаагүй зээлдэгч нар мал тооллогод хамрагдсан байна. Арилжааны банк нь зээл олгохдоо мал тооллогын нотлох баримтаар E-Mongolia-аас авсан Мал тооллогын лавлагаа авалгүй, А дансны хуулбарыг авч баталгаажуулсан нь дээрх зээл авсан малчдад зээл олгохдоо Ерөнхий гэрээнд заасны дагуу олгоогүй тул шалгуур хангаагүй зээл олгосон гэж үзсэн болно.

Хүснэгт 4. Банкнуудын зээлийн шалгуур хангаагүй зээлдэгчийн тооны мэдээлэл

| № | Зээл олгосон банк                          | Зээлдэгчийн тоо | Хувь  | Шалгуур хангаагүй зээлдэгчийн тоо | Хувь  |
|---|--------------------------------------------|-----------------|-------|-----------------------------------|-------|
| 1 | Баян-Өлгий аймаг дахь ХААН банкны салбар   | 47              | 15.2% | 8                                 | 17%   |
| 2 | Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны салбар | 263             | 78.7% | 56                                | 21.3% |

Эх сурвалж:Аудитын судалгаа

Хаан банкны салбараас зээл олгосон 47 зээлдэгчийн 17 хувь буюу 8 зээлдэгч, Төрийн банкнаас зээл олгосон 263 зээлдэгчийн 21.3 хувь буюу 56 зээлдэгч шалгуур хангаагүй байна.

Хүснэгт 5.

Шалгуур хангаагүй зээлийн дүн

(сая төгрөгөөр)

| Д/Д | Зээл олгосон банк                          | Нийт олгосон зээлийн дүн | Шалгуур хангаагүй зээлийн дүн | Хувь  |
|-----|--------------------------------------------|--------------------------|-------------------------------|-------|
| 1   | Баян-Өлгий аймаг дахь ХААН банкны салбар   | 866.6                    | 177.0                         | 20.4% |
| 2   | Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны салбар | 6,861.7                  | 1,290.5                       | 18.8% |

Эх сурвалж:Аудитын судалгаа

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Баян-Өлгий аймаг дахь ХААН банкны салбар 866.6 сая төгрөгийн зээл олгосноос 177.0 сая төгрөг буюу 20.4 хувь нь, Төрийн банкны салбар 6,861.7 сая төгрөгийн зээл олгосноос 1,290.5 сая төгрөг буюу 18.8 хувь нь шалгуур хангаагүй зээл байна.

Аудитаар зээл хүсэгчдийн малчин эсэхийг баталгаажуулах зорилгоор арилжааны банкуудын E-Mongolia-оос авсан малчны тодорхойлолтыг Баян-Өлгий аймаг дахь Статистикийн хэлтсээс авсан малчдын мал тооллогын судалгаатай тулган шалгахад мэдээллийн зөрүү илэрсэн.Тухайлбал:

E-Mongolia-ийн тодорхойлолтод “малчин” гэж бүртгэгдсэн 22 зээлдэгч Статистикийн хэлтсийн мал тооллогын мэдээлэлд “мал бүхий иргэн” гэж бүртгэгдсэн байна. Энэ нь төрийн байгууллагуудын мэдээлэл зөрүүтэй, уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна. “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 3.1.1-т “зээл хүсэгч нь хоршооны гишүүн малчин байх” гэсэн шаардлагыг хангасан малчинд зээл олгосон эсэхийг нотлох боломжгүй байна.



“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Аудитын дүнгээр тус аймагт “Төрөөс хэрэгжүүлж буй Шинэ хоршоо-чинээлэг малчин арга хэмжээний хүрээнд” Төрийн банк болон Хаан банкны салбарууд хоршооны гишүүн малчинд зээл олгохдоо “Ерөнхий гэрээний зээл хүсэгчид тавих шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримт болох төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ийн “Мал тооллогын лавлагаа”-г нотлох баримтаар авалгүй, оршин сууж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тодорхойлолт”-ыг үндэслэлгүйгээр өөр сумын иргэнд зээл олгосон зөрчлүүд илэрсэн тул зөрчлийг арилгах талаар аймаг дахь ХААН банк, Төрийн банкны салбарт **тус бүр 1 заалт бүхий зөвлөмж** өгөгдлөө.

## 2.2.2 Зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж байна

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.11<sup>25</sup>, 2.1.14<sup>26</sup>, 2.1.15<sup>27</sup> дэх заалтуудад зээл төлөх хэлбэр, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа, эргэн төлөх үүргийг баталгаажуулах аргын талаар тусгасан.

Хоршооны гишүүн малчны зээл олгосон арилжааны банкнууд тухайн банкны хоршооны гишүүн малчны зээлийн гэрээндээ зээлийг эргэн төлөх хугацааг “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2.1.11-т тусгасны зээлдэгчийн малын ашиг шимийн орлоготой уялдуулан зээлийн эргэн төлөлтийн хуваарийг, 2.1.14-т тусгасны дагуу үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг зээлдэгчийн орлоготой уялдуулан зээлдэгчтэй хамтран тогтоосон байна.

Зээлийг эргэн төлөх үүргийн талаар: Төрийн банкны зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2-т “Зээлдэгч буюу барьцаалуулагч дараах үүргийг хүлээнэ”, 3.2.1-д “Үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөрийг “Зээлийн эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу хугацаанд нь бүрэн төлөх” гэж тусгасан байна.

ХААН банкны зээлийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2.1-д зээлдэгчийн зээлээ эргэн төлөх үүргийн талаар “Зээлийн төлбөрийг сар бүр тоот харилцах дансанд төвлөрүүлж “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу төлөх эсхүл “Зээл олголт, эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу шууд зээлийн дансанд төлөх” гэж тусгасан байна.

Хүснэгт 6. Баян-Өлгий аймгийн “Хоршооны гишүүн малчны зээлийн мэдээлэл (сая төгрөгөөр)

| № | Зээл олгосон банк                          | Зээлдэгчийн тоо | Хувь        | Зээлийн дүн     | Хувь        |
|---|--------------------------------------------|-----------------|-------------|-----------------|-------------|
| 1 | Баян-Өлгий аймаг дахь ХААН банкны салбар   | 47              | 15.2%       | 866.6           | 11.2%       |
| 2 | Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны салбар | 263             | 84.8%       | 6,861.70        | 88.8%       |
|   | <b>Дүн</b>                                 | <b>310</b>      | <b>100%</b> | <b>7,728.30</b> | <b>100%</b> |

<sup>25</sup>2.1.11 Зээл төлөх хэлбэр нь: “Зээлдэгчийн малын ашиг шимийн орлоготой уялдуулан зээлийн эргэн төлөлтийн хуваарийг банк, зээлдэгч харилцан тохиролцож байгуулна”

<sup>26</sup>2.1.14 Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа: “Зээлдэгчийн орлоготой уялдуулан банк зээлдэгчтэй хамтран тогтоох бөгөөд 12 сараас хэтрэхгүй”

<sup>27</sup>2.1.15 Зээлийг эргэн төлөх үүргийг баталгаажуулах арга: “Иргэний хууль, Банкны тухай хууль, холбогдох хууль тогтоомжид нийцсэн банкны дотоод журмын дагуу баталгаажуулна”

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Эх сурвалж:Аудитын судалгаа

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд аймаг дахь Хаан болон Төрийн банкны салбарууд 150 хоршооны 310 зээлдэгчид 7,728.3 сая төгрөгийн зээл олгосон байна. Хаан банк 47 зээлдэгчид 866.6 сая төгрөгийн, Төрийн банк 263 зээлдэгчид 6,861.7 сая төгрөгийн зээл олгосон байна. Тус аймагт Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон зээлийн 88.8 хувийг Төрийн банкаар дамжуулан олгосон байна.

Хүснэгт 7. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд олгосон малчны зээлийн үлдэгдэл  
/2026 оны 3 дугаар сарын 31-ны байдлаар/ (сая төгрөгөөр)

| Д/Д | Зээл олгосон банк                          | Зээлдэгчийн тоо | Хувь        | Зээлийн үлдэгдэл | Хувь        |
|-----|--------------------------------------------|-----------------|-------------|------------------|-------------|
| 1   | Баян-Өлгий аймаг дахь ХААН банкны салбар   | 47              | 15.4%       | 659.7            | 10.8%       |
| 2   | Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны салбар | 258             | 84.6%       | 5,459.20         | 89.2%       |
|     | <b>Дүн</b>                                 | <b>305</b>      | <b>100%</b> | <b>6,118.90</b>  | <b>100%</b> |

Эх сурвалж:Аудитын судалгаа

Зээлийн үлдэгдэл 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 6,118.9 сая төгрөг ба 1,401.8 сая төгрөгийн зээлийн төлбөр төлөгдсөн байна.

Хаан банк дахь Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчдад олгосон зээлийн үлдэгдэл 659.7 сая төгрөг, Төрийн банкны үлдэгдэл 5,459.2 сая төгрөг байна.

Төрийн банкнаас зээл авсан 5 зээлдэгч 42.5 сая төгрөгийн зээлийг хугацаанаас өмнө төлсөн байна.

Хүснэгт 8. Зээлийн чанарын байдал (сая төгрөгөөр)

| № | Зээлийн чанарын үзүүлэлт | Зээлдэгчийн тоо | Хувь        | Зээлийн үлдэгдэл | Хувь        |
|---|--------------------------|-----------------|-------------|------------------|-------------|
| 1 | Хэвийн зээл              | 303             | 99.30%      | 6,057.80         | 99%         |
| 2 | Чанаргүй зээл            | 2               | 0.70%       | 61.1             | 1%          |
|   | <b>Дүн</b>               | <b>305</b>      | <b>100%</b> | <b>6,118.90</b>  | <b>100%</b> |

Эх сурвалж:Аудитын судалгаа

Шинэ хоршоо хөдөлгөөний зээлийн чанарын талаар судалж үзэхэд: Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд зээл авсан зээлдэгч нараас 2026 оны 03 дугаар сарын 31-ны байдлаар 6,118.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа 305 зээлдэгчээс 303 зээлдэгчийн 6,057.8 сая төгрөгийн зээл хэвийн ангилал байгаа ба 2 зээлдэгчийн 61.1 сая төгрөгийн зээл чанаргүй ангилалд шилжсэн байна. Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээл 1 хувийг эзэлж байна.

Зээл олгосон банкуудаар зээлийн чанарыг судалж үзэхэд ХААН банкнаас зээл авсан 47 зээлдэгчийн 659.7 сая төгрөгийн зээлээс хугацаа хэтэрсэн зээл байхгүй, хэвийн төлөлттэй байна. Төрийн банкны 258 зээлдэгчийн 5,459.2 сая төгрөгийн зээлийн үлдэгдлээс 5,398.1 сая төгрөг нь хугацаандаа төлөгдөж хэвийн

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

ангилалд байгаа бол 61.1 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрч ангилал буурсан байна.

Ангилал буурсан 1 зээлдэгчийн зээлийг шүүхэд нэхэмжлэл гаргасан ба Баян-Өлгий аймаг дахь сум дундын анхан шатны шүүхээс 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 302/ШШ2025/01109 дугаартай шүүхийн шийдвэрээр зээлдэгчээс 28.1 сая төгрөгийг гаргуулан Төрийн банкны Баян-Өлгий аймаг дахь салбарт олгохоор шийдвэрлэсэн байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 9 дүгээр зүйлийн 9.1.<sup>28</sup>, 9.1.1<sup>29</sup>, 9.1.2<sup>30</sup> дэх заалтуудад зээлийн талаар тайлан мэдээ солилцож ажиллах алаар тусгасны дагуу арилжааны банкнууд зээл олголт, зээлийн үлдэгдэл болон чанарын мэдээллийг цахим хэлбэрээр сар бүр, Засгийн газрын хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлтийн тайланг хавсралтаар баталсан загвараар сар бүр гаргаж Арилжааны төв банкандаа хүргүүлж ажилласан байна.

### 2.2.3 Арилжааны банкнууд хоршооны гишүүн малчны зээлд журамд заасны дагуу тогтмол хяналт хэрэгжүүлээгүй, хяналт үр дүнгүй байна

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8 дахь хэсгийн 8.1.<sup>31</sup>, 8.2.<sup>32</sup>, 8.3.<sup>33</sup> дахь заалтуудаар Арилжааны банк, Монгол банкны орон нутаг дахь нэгж, Зээлийн батлан даалтын сангуудын хяналт хэрэгжүүлэх үүргийг тусгасан байна.

#### Хүснэгт 9. Хоршооны гишүүн малчны зээл”-д хэрэгжүүлсэн хяналт

| Банкны нэр                      | “Хоршооны гишүүн малчны зээл” |                                        |      |                                        |      |                               |                                        |      |
|---------------------------------|-------------------------------|----------------------------------------|------|----------------------------------------|------|-------------------------------|----------------------------------------|------|
|                                 | Зээлдэгчийн тоо               | Арилжааны банкны аймаг дахь салбарууд  |      | Монголбанкны орон нутаг дахь нэгж      |      | Зээлийн батлан даалтын сан    |                                        |      |
|                                 |                               | Хяналт, шалгалт хийсэн зээлдэгчийн тоо | Хувь | Хяналт, шалгалт хийсэн зээлдэгчийн тоо | Хувь | Батлан даасан зээлдэгчийн тоо | Хяналт, шалгалт хийсэн зээлдэгчийн тоо | Хувь |
| Төрийн банкны аймаг дахь салбар | 263                           | 179                                    | 68.1 | 20                                     | 6.5  | 5                             | 2                                      | 40   |
| Хаан банкны аймаг дахь          | 47                            | 40                                     | 85.1 | 47                                     | 15.2 | 2                             | 2                                      | 100  |

<sup>28</sup>9.1 Банк дараах мэдээллийг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллана. Үүнд:

<sup>29</sup>9.1.1 Банканд хуваарилсан санхүүжилт дуусах хүртэл зээлийн хүсэлт, зээл олголт, зээлийн үлдэгдэл болон чанарын мэдээллийг цахим хэлбэрээр энэ гэрээний Нэгдүгээр хавсралтаар баталсан загварын дагуу Монголбанканд сар бүр

<sup>30</sup>9.1.2 Засгийн газрын хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлтийн тайланг энэ гэрээний Хоёрдугаар хавсралтаар баталсан загварын дагуу Монголбанканд сар бүр

8.1 Банкны дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад хагас жил тутам хяналт тавьж, дотоод аудитын тайланг хагас жил тутам Монголбанканд хүргүүлнэ.

8.2 Монгол банкны орон нутаг дахь нэгж “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад зайны хяналт галгалтыг хийнэ. Хяналт шалгалт хийхдээ холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос тусалцаа дэмжлэг авч болно.

8.3 Зээлийн батлан даалтын сан “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавина. Хяналт тавихтай холбоотойгоор төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооноос тусалцаа, дэмжлэг авч болно

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

|             |            |            |      |    |      |   |   |      |
|-------------|------------|------------|------|----|------|---|---|------|
| салбар      |            |            |      |    |      |   |   |      |
| <b>Бүгд</b> | <b>310</b> | <b>219</b> | 70.6 | 67 | 21.6 | 7 | 4 | 57.1 |

Эх сурвалж: Аудитын судалгаа

Санхүүжилтийн ерөнхий гэрээний 8.2-д заасны дагуу Монгол банкны аймаг дахь салбар “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад зайны хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Монгол банкны ерөнхийлөгчийн 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Баян-Өлгий салбарын захирлын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Төрийн банкнаас олгосон “Шинэ хоршоо малчны зээл”-ээс түүвэрлэж 20 зээлдэгчийн материалд зайнаас хяналт хийсэн байна.

Хяналтаар 4 зээлдэгчийн барьцааны гэрээнд “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.<sup>34</sup> дэх заалт, Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.2.<sup>35</sup> дахь заалтуудыг зөрчсөн, Төрийн банкны зээлийн бүтээгдэхүүн журмын 3.16-д заасныг буюу хамтран өмчлөгчийн мэдээлэллийг дутуу оруулсан зөрчлүүд илэрсэн байна.

Монгол банкны ерөнхийлөгчийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, Баян-Өлгий салбарын захирлын 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ХААН банкнаас “Шинэ хоршоо малчны зээл” авсан 47 зээлдэгчийн зээлд зайны хяналт хийсэн байна. Хяналтаар ямар нэг зөрчил илрээгүй байна.

Монгол банкны аймаг дахь салбарын эдийн засагч нь зээлийн батлан даалтын сан хариуцсан төлөөлөгчийн ажлыг давхар хариуцаж ажилладаг байна.

Тус аймгийн хоршооны гишүүн малчны зээл авсан Сагсай, Буянт, Алтанцөгц, Бугат, Цэнгэл сумын тус бүр, Ногооннуур сумын 2, нийт 7 зээлдэгчийн авсан 245.0 сая төгрөгийн зээлийг зээлийн батлан даалтын сангаас 182.0 сая төгрөгөөр батлан даасан байна.

Аймаг дахь Төрийн банк болон ХААН “Шинэ хоршоо малчны зээл”-д зайны хяналт шалгалт хийхдээ зээлийн батлан даалт гаргасан зээлүүдэд давхар хяналт хийсэн эсэхийг хяналт хийсэн жагсаалтаас харахад:

Төрийн банкнаас зээл авсан 2 зээлдэгчийн, ХААН банкнаас зээл авсан 2 зээлдэгчийн зээлд хяналт хэрэгжүүлсэн нь Зээлийн батлан даалтын сангаас батлан даасан зээлдэгчийн 57.1 хувьд хяналт хийсэн байна.

“Хоршооны гишүүн малчны зээл”-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 8 дахь хэсгийн 8.1-д заасны дагуу арилжааны банкууд “Хоршооны гишүүн малчны зээл”-ийн ашиглалт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж ажилласан байна.

<sup>11.1.</sup>Барьцааны гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр, эсхүл цахим хэлбэрээр байгуулах бөгөөд түүнд Иргэний хуулийн 156.2-т зааснаас гадна дараахь зүйлийг тусгана:  
<sup>156.2.</sup>Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг, улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

Төрийн банк 179 зээлд хяналт хэрэгжүүлсэн нь нийт олгосон зээлийн 68.1 хувийг, ХААН банк 40 зээлд хяналт хэрэгжүүлсэн нь олгосон зээлийн 85.1 хувийг эзэлж байна.

Арилжааны банкнууд 219 зээлдэгчийн зээлд хяналт хэрэгжүүлсэн нь 70.6 хувьтай байна.

Арилжааны банкнуудын хоршооны гишүүн малчны зээлд хийсэн дотоод хяналтын талаар:

Төрийн банкны “Хоршооны гишүүн малчны зээлийн журам”-ын 41.9-д “Зээлийн хяналт ба эргэн төлөлт”, 41.9.1-д “Зээлийн ажилтан нь зээлийн эргэн төлөлтөд сар бүр зайнаас тогтмол хяналт тавьж ажиллах ба ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж тайланг хагас жил тутам ИБЗҮАХХА-д хүргүүлнэ” гэж заасан.

Төрийн банк нь зээлийн явцын хяналт хийсэн боловч хяналт тайлан болон нотлох баримт хангалтгүй, журмын дагуу хагас жил тутамд хяналт хийгээгүй байна.

ХААН банкны “Зээлийн үйл ажиллагааны журам”-ын 6.10-т “Хяналт тавих хэсгийг ерөнхий чиглэл болгон ажиллана”, 6.10.6-д “Газар дээрх хяналт”, 6.10.6.2-т “Бүх төрлийн төслийн зээлийн хувьд (дүн харгалзахгүй) зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэхийг зээл олгосноос хойш нэг сарын дотор хянах ба зээлийн зориулалт бүрээр хангагдах хүртэл газар дээрх хяналтыг үргэлжлүүлэн хийж баримтаар баталгаажуулна”, 6.10.6.3-т “Салбарын ЗБХМ/ТТХМ нь харьяа Тооцооны төв тус бүрийн хөдөө аж ахуйн салбарт олгосон зээл (тухайлбал газар тариалан, малчин гэх мэт)-ийг жилд нэгээс доошгүй удаа түүвэрчилсэн байдлаар тулгалт хийж баталгаажуулна” гэж заасан байна.

ХААН банк нь зээл олгосны дараах хяналтыг журмын дээрх заалтын дагуу хяналт хийсэн боловч хяналтын тайлан хангалтгүй, нотлох баримтаар баталгаажаагүй, анх хяналт хийснээс хойш явцын хяналт хийгдээгүй байна.

Аудитын дүнгээр аймаг дахь ХААН банк, Төрийн банкны салбарт хоршооны гишүүн малчны зээлд тавих хяналтыг журамд заасан хугацаанд чанартай хийж, холбогдох нотлох баримтаар баталгаажуулж байх талаар аймаг дахь ХААН банк болон Төрийн банкны салбаруудад **тус бүр нэг заалт бүхий зөвлөмж** өгөв.

#### **2.2.4 Хөнгөлөлттэй зээл авсан малчдын 1 хувь нь зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна**

Тус аймгаас Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хоршооны гишүүн нь зээл авсан хоршоод нь анхан хоршоод байна. Эдгээр хоршоодын гишүүд Ерөнхий гэрээний 2.1.1-д заасан зориулалтыг хангасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх хариуцлагын гэрээ байгуулсан байна.

Хоршооны гишүүд нь хамтарч хэрэгжүүлсэн 2 төсөл, арга хэмжээ байгаа ба бусад хоршооны гишүүн малчны зээл авсан зээлдэгчид төсөл, арга хэмжээгээ тус тусдаа хэрэгжүүлсэн байна. Зээлийн хүсэлт гаргасан хоршооны зарим гишүүдэд зээл олгогдоогүй байна.

“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

"Хоршооны гишүүн малчны зээл"-ийн санхүүжилтийн ерөнхий гэрээний дагуу арилжааны банкнаас хийсэн хяналтаар зээлийг зориулалт бус зарцуулсан талаар зөрчил илрүүлсэн тохиолдол байхгүй байна.

Хоршооны гишүүн малчны зээлийн эргэн төлөлт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүнгээр зээлийг зориулалт бус зарцуулсан нийт 48.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Төрийн банкнаас 48.0 сая төгрөгийн зээл авсан 3 зээлдэгч авсан зээлийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрсэн. Үүнд:

- *20.0 сая төгрөгийн зээл авсан 1 зээлдэгч харилцах данснаас юунд зарцуулсныг нотлох баримтгүйгээр бага багаар зарцуулалт хийсэн,*
- *20.0 сая төгрөгийн зээл авсан 1 зээлдэгч 20.0 сая төгрөгөөр автомашин худалдах, худалдан авах гэрээ байгуулж тухайн иргэний данс руу шилжүүлсэн боловч машин нэр дээр нь шилжээгүй,*
- *8.0 сая төгрөгийн зээл авсан 1 зээлдэгч өвс, тэжээл худалдан авсан,*

Аудитын дүнгээр аймаг дахь Төрийн банкны салбарт хоршооны гишүүн малчны зээлийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналтын хангалтгүй хэрэгжүүлснээс авсан зээлээ зориулалт бус зарцуулсан зөрчлийг илрүүлээгүй байдалд анхаарч, хяналтыг чанартай хэрэгжүүлэх, Хоршооны гишүүн малчны зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээний 2.3-т заасан гэрээг цуцлах нөхцөл бүрдсэн 3 зээлдэгчид олгосон 48.0 сая төгрөгийн зээлийн гэрээг цуцалж, зээлийн хүүгийн хөнгөлөлтийг зээл олгосон үеэс нөхөн хуримтлуулж, нэхэмжилж, ХХААХҮЯ-д зээлдэгчээр нөхөн төлүүлэхээр **албан шаардлага** өгөгдлөө.

## **ДҮГНЭЛТ:**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө"-г орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж аймгийн дэд төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
2. Шинээр үүсгэн байгуулагдсан хоршоод хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаагаа үнэн зөв тайлагнаж ажиллаагүй байна.
3. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд зээл олгосон нийт зээлдэгчийн 19.7 хувь нь санхүүжилтийн ерөнхий гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.3-д заасан шалгуурыг хангаагүй байна.
4. Нийт олгосон зээлийн 99 хувь нь хэвийн ангилалд байна.
5. Арилжааны банкнууд хоршооны гишүүн малчны зээлд журамд заасны дагуу тогтмол хяналт хэрэгжүүлээгүй байна.
6. Хөнгөлөлттэй зээл авсан малчдын 1 хувь нь зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

### **I.Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:**

1. Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд хөнгөлөлттэй зээл авсан хоршоодын санхүүгийн тайлан гаргах, нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж ажиллах;

### **II. Баян-Өлгий аймаг дахь ХААН болон Төрийн банкны салбарын захирлуудад:**

1.Ерөнхий гэрээний зээл хүсэгчид тавих шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримт болох төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ийн “Мал тоологын лавлагаа”-г нотлох баримтаар авалгүй, оршин сууж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тодорхойлолт”-ыг үндэслэлгүйгээр өөр сумын иргэнд зээл олгосон зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх;

2.Хоршооны гишүүн малчны зээлд тавих хяналтыг журамд заасан хугацаанд чанартай хийж, холбогдох нотлох баримтаар баталгаажуулах;

*Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг арилжааны банкнууд 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс 2027 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.*



“Шинэ хоршоо хөдөлгөөн”д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУДЫН САНАЛ :

|                                                                                   |                                                                                     |                                                                                                                                              |
|-----------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  | <b>ХААН БАНК</b>                                                                    | ХХД-9007001013<br>БАЯН-ӨЛГИЙ САЛБАР<br>Баян-Өлгий аймаг,<br>Өлгий сум, 5-р баг<br><br><a href="http://www.khanbank.com">www.khanbank.com</a> |
| 2026 оны 06 дугаар<br>сарын 30-ны өдөр                                            | Дугаар 5780/<br>582                                                                 | Өлгий сум                                                                                                                                    |
| БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ<br>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР                                     |                                                                                     |                                                                                                                                              |
| Хариу хүргүүлэх тухай                                                             |                                                                                     |                                                                                                                                              |
| Ирүүлсэн тайлантай танилцлаа. Нэмэлт санал байхгүй байна.                         |                                                                                     |                                                                                                                                              |
| САЛБАРЫН ЗАХИРАЛ                                                                  |  | Л.ӨНӨРЖАРГАЛ                                                                                                                                 |
| 26-1475                                                                           |                                                                                     |                                                                                                                                              |



## ТӨРИЙН БАНК

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН БАНКНЫ САЛБАР

83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 5 дугаар баг  
Утас/ Факс: 7042-2978

2026.06.30

№

47/509

танай

-ны

### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР-т

Төрийн банкны Баян-Өлгий салбарын “Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан ба санал, хүсэлт байхгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн:

САЛБАРЫН ЗАХИРАЛ



Д.РАЯ

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

11 дүгээр баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг, 83129

Утас/Факс: (976) 7042 3762,

Цахим шуудан: info@bo.gov.mn,

Цахим хуудас: www.bayan-olgi.gov.mn

2026.06.30 № 3/1626

танай 2026.06.29-ны № 481 -Т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЖЕНИСБЕК ТАНАА**

“Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл,  
эргэн төлөлт, үр дүн сэдвээр хийсэн гүйцэтгэлийн  
тайлангийн төсөлтэй танилцав.

Санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **Ө.ТИЯНАХ**



8326150303

## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/16

Өлгий

#### Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-д олгосон зээл, эргэн төлөлт, үр дүн сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, албан шаардлагыг 2 дугаар хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн Засаг даргын тамгын газар, Баян-Өлгий аймаг дахь Төрийн банк, ХААН банкны салбарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитор (Ш.Нурлан)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Д.Назгүл)-д тус тус даалгасугай.
4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 10 хоногт багтаан аудитын тайлан, нотлох баримтуудыг архивын нэгж болгон архивд хүлээлгэж өгөхийг аудитын багт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЖЕНИСБЕК



882601000033

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудиторын 2026 оны 06 дугаар  
сарын 30-ны өдрийн А/16 дугаар тушаалын  
01 дугаар хавсралт

Б3117143071  
БНГА/0374 9007245

(мянган төгрөг)

| № | Байгууллагын нэр                           | Албан шаардлага |                 |
|---|--------------------------------------------|-----------------|-----------------|
|   |                                            | Тоо             | Дүн             |
| 1 | Баян-Өлгий аймаг дахь Төрийн банкны салбар | 1               | 48,000.0        |
|   | <b>Дүн</b>                                 | <b>1</b>        | <b>48,000.0</b> |